

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	17
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/831
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Монгол шуудан" ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Монгол шуудан” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлагыг данснаас хасах талаар дээд шатны төсөв захирагчид хандаж шийдвэрлүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн шинэчлэх, санхүүгийн программд холбогдох сайжруулалтыг хийх, стандарт, хууль тогтоомжид нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэж байх, дотоод хяналт тогтолцоог сайжруулах, эд хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол шуудан” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Монгол шуудан” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол шуудан” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 17-ноос 2020 оны 3 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК-ийн ерөнхий захирал, удирдах партнер Б.Осоргарав, чанарын хянагч Н.Эрдэнэцог, аудитын менежер Б.Дэлгэрмаа, аудитор Б.Алтансарнай, туслах аудитор М.Батцоож, туслах аудитор Д.Буянтогтох нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монгол шуудан” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 01/156 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмыг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Монгол шуудан” ХК нь “Дэлхийн дэвшилтэд технологид хүрсэн, чанартай, цогц үйлчилгээгээр хүн бүрийн шуудангийн хэрэгцээг төгс хангах” гэсэн чиглэл зорилтыг тодорхойлон ажиллажээ.

“Монгол шуудан” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Захидал, бичиг, боодол, илгээлт зэрэг шуудангийн бүх нийтийн үйлчилгээ;
- Захиалгат илгээмжийн худалдаа;
- Хадгаламж, даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс олгох, мөнгөн гуйвуулга хийх зэрэг санхүүгийн үйлчилгээ;
- Шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, хэвлүүлэх, борлуулах;
- Гадаад дотоодын тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх, борлуулах;
- Монгол Улсын Шуудангийн тухай хуулиар зохицуулсан бусад үйлчилгээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

“Монгол шуудан” ХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Veritech ERP” программ хангамж ашигладаг байна.

“Монгол шуудан” ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 18 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 14,465.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 144.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 0.5 хувь болох 72.3 сая төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Монгол шуудан” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 524.9 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,267.1	16,648.9	(618.2)
Авлага	6,168.1	5,242.8	(925.4)
Урьдчилгаа	106.9	189.4	82.5
Бараа материал	2,095.1	2,383.7	288.5
Үндсэн хөрөнгө	8,373.6	9,021.1	647.5
Нийт хөрөнгө	34,010.9	33,485.9	(525.0)
Өр төлбөр	11,498.4	10,562.3	(936.1)
Эздийн өмч	22,512.5	22,923.6	411.1
Нэмж төлөгдсөн капитал			
Хуримтлагдсан ашиг, алдагдал			
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	34,010.9	33,485.9	(525.0)

Тайлант оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансуудад дараах материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 618.2 сая төгрөгөөр буурсан нь олон улсын транзит шуудангийн харилцагчийн үлдэгдэл төлбөрийг төлснөөс шалтгаалсан байна.
- Авлага дансны үлдэгдэл 925.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны олон улсын транзит шуудангийн үйлчилгээний төлбөрийг хүлээн авсан, мөн хэвлэлийн авлагууд төлөгдсөнөөс шалтгаалжээ. Авлагын дансны үлдэгдэлд он удаан жил болсон авлагын үлдэгдэл байхгүй байна. Авлагын үлдэгдэлд 3,854.8 сая төгрөгийн улс хоорондын шуудангийн тооцооны авлага, 364.8 сая төгрөгийн хүүгийн авлага зэрэг байна.
- Урьдчилгаа данс 82.5 сая төгрөгөөр өссөн нь 40.9 сая төгрөгийн ялган боловсруулах төв болон 24.7 сая төгрөгийн олон улсын транзит шуудантай холбоотой объектын түрээсийн зардлыг урьдчилж төлсөн мөн 38.8 сая төгрөгийн дэлхийн шуудан холбоо, ази номхон далайн бүсийн шуудан холбооны гишүүнчлэлийн төлбөрийг урьдчилж төлснөөс шалтгаалжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 288.5 сая төгрөгөөр өссөн нь дотоодын дугтуй үйлдвэрлэл болон маркын захиалгат үйлдвэрлэл өссөнөөс шалтгаалжээ. Бараа материал дансны үлдэгдэлд тайлант онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 647.5 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагаанд ашиглахаар 1,251.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдан авснаас шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 2,044.6 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байхгүй. Салбар болон эд хариуцагч хооронд 524.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.
- Өглөгийн дансны үлдэгдэл 936.1 сая төгрөгөөр буурсан олон улсын транзит шуудангийн харилцагчийн үлдэгдэл төлбөрийг төлснөөс шалтгаалсан байна.
- Өглөгийн үлдэгдэлд 8,444.9 сая төгрөгийн транзит тээврийн өглөг, 344.8 сая төгрөгийн захиалгат хэвлэлийн өглөг зэрэг байна.

- Эздийн өмч дансны үлдэгдэл өссөн нь 1,103.6 сая төгрөгийн тайлант хугацааны цэвэр ашиг, 468.1 сая төгрөгийн зарласан ногдол ашгийн зөрүү болон өмнөх үеийн алдааны залруулгын дүнгээс шалтгаалжээ.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 224.4 сая төгрөгийн бичилт нь 83.9 сая төгрөгийн нөхөн татвар болон 140.4 сая төгрөгийн гүйцэтгэх удирдлагын багт олгосон урамшуулалтай холбоотой байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 18/13 дугаар тогтоолоор “Монгол шуудан” ХК-ийн 2019 оны бизнес төлөвлөгөөг баталж, 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 19/08 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна.

“Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал нь тус компанийн ТУЗ-тай “Үр дүнгийн гэрээ” байгуулан ажилладаг байна.

Хүснэгт: Зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	15,929.2	16,725.0	(795.8)	105.0
Нийт зардал	15,159.2	15,506.6	(347.4)	102.3
Татварын өмнөх ашиг	770.0	1,218.4	(448.4)	158.2
Орлогын татварын зардал	77.0	114.9	(37.9)	149.2
Цэвэр ашиг	693.0	1,103.6	(410.5)	159.2
Ногдол ашиг	207.9	331.1	(123.2)	159.2

2019 онд 16,725.0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 709.7 сая төгрөгөөр буюу 105 хувиар давуулан биелүүлсэн байна. Борлуулалтын орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар буюу 1,251.1 сая төгрөгөөр өссөн байна.

2019 онд 15,506.7 сая төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаа явуулж, зардлын төлөвлөгөөг 347.4 сая төгрөг буюу 102 хувиар хэтрүүлсэн байна. Зардлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар буюу 1,272.8 сая төгрөгөөр өссөн байна.

Зардлын өсөлтөд нөлөөлсөн гол үзүүлэлт нь транзит шуудангийн орлогын өсөлттэй холбоотойгоор тээврийн зардал 265.0 сая, ам.долларын ханшийн өсөлттэй холбоотой улс хоорондын шуудангийн зардал 144.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Татварын өмнөх ашгийг 448.4 сая төгрөгөөр буюу 158.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Татварын өмнөх ашгийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 43.0 хувиар буюу 523.9 сая төгрөгөөр өссөн байна.

2019 онд 410.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн төлөвлөгөөг 59.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Цэвэр ашгийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 456.7 сая төгрөгөөр буюу 41.4 хувиар өссөн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 30 эрсдэл тодорхойлж, нийт 29 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 458.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 394.0 сая төгрөгийн алдааг залруулж, 43.1 сая төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 21.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд 20.9 сая төгрөгийн авлага, 373.1 сая төгрөгийн өглөг хасах утгатай үлдэгдэл бүртгэсэн байна. Энэ нь авлага, өглөгийг дүнг материаллаг хэмжээгээр бууруулж тайлагнаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4.-д “үнэн зөв байх” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингаас 3.2 сая төгрөгийн ХХОАТ дутуу суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2006 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно”, 17.1.2-д “энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан орлогын тухайд нийлбэр дүнгээр нь тооцож тодорхойлно”, 11.1.4-д “Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж, ажиллах, ТУЗ-д илүү олгосон урамшууллыг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Тайлант хугацаанд нийт 8 ажилтанд анхан шатны баримтгүйгээр 39.9 сая төгрөгийн цалин олгосон нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж, холбогдох хувь хүмүүсээр буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

4. “Идеал Групп” ХХК-д төлсөн 21.8 сая төгрөгийн барилгын зураг төслийн ажлын хөлсийг 2009 онд Урьдчилж төлсөн зардлаар бүртгэснийг залруулах талаар өмнөх онд зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь Монгол улсын Ерөнхий аудиторын Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6-р заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх жилийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

5. Авто тээврийн үндэсний төвөөс ирүүлсэн компанийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслийн лавлагаагаар нийт 162 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй, компанийн нягтлан бодох бүртгэлд 141 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Үүний 5 машин нь компанийн нэр дээр бүртгэлгүй, 27 машин нь компанийн бүртгэлд тусгаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийн арилгах албан шаардлага өгсөн.

6. Харилцагч байгууллагатай авлага, өглөгийн тооцоо нийлж, үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага өгөх.

7. "Монгол шуудан" ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага өгөх.

8. 2019 онд 15,506.7 сая төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаа явуулж, зардлын төлөвлөгөөг 347.4 сая төгрөг буюу 102 хувиар хэтрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-д "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 21 дүгээр зүйлийн 11-д "Төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлтэй тухайн хуулийн этгээдийн хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянах..." гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтыг сайжруулах талаар 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-ын дагуу НББ-ийн бодлогыг зөв зохистой тодорхойлж, шуудангийн үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэсэн байдал, СТОУС 16 Түрээс-ийн дагуу түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, түрээсийн өр төлбөрийн хүүгийн хувь хэмжээг тодорхойлсон байдал, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-ийн дагуу санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцох аргачлалыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо зөв тодорхойлж, Нягтлан бодох бүртгэлдээ хүлээн зөвшөөрсөн байдал, хойшлогдсон татвартай холбоотой түр зөрүүний тооцоолол, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн тохируулга, эздийн өмчийн бусад хэсгийн дүнгийн тохируулга зэргийг нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Монгол шуудан” ХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Монгол шуудан” ХК нь 2019 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээлэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 11 мэдээлэл, нийт 12 мэдээллийг оруулсан ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 2019 оны 1, 2 дугаар саруудад хугацаа хоцорч байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.08 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 0.08 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 8 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гараагүйгээс “21.8 сая төгрөгийн барилгын зураг төслийн ажлын хөлсийг 2009 онд Урьдчилж төлсөн зардлаар бүртгэснийг залруулах талаар” 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 87.5 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Монгол шуудан” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Монгол шуудан” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Компани нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан, 10-с дээш жил болсон зэрэг авлагад найдваргүй авлагын нөөц байгуулсан боловч данснаас хасаагүй байгаа нь СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-ийн 5.4.4-д "Санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бүхэлд нь нөхнө гэсэн үл үндэслэлтэй хүлээлтгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн дансны үнийг шууд бууруулж данснаас хасна" гэж заасанд нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох стандарт, хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байх;

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Авлагыг данснаас хасах талаар дээд шатны төсөв захирагчид хандаж шийдвэрлүүлэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 онд боловсруулан мөрдөж байна. Тус баримт бичигт Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС болон СТОУС-ын холбогдох өөрчлөлтүүдийг тусгаж, шинэчлээгүй байна. Тухайлбал:

- СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр”-ийн дагуу компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хэрхэн ангилж, хүлээн зөвшөөрч, үнэ цэнийн бууралтыг тооцох бодлогыг нарийвчлан тусгаагүй,
- СТОУС 15 “Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого”-ын дагуу шуудангийн үйлчилгээний гэрээнд заасан нөхцөлийг харгалзан үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрөх бодлогыг нарийвчлан боловсруулаагүй,
- СТОУС 16 “Түрээс”-ийн дагуу урт хугацаат, материаллаг хэмжээний түрээсийн хувьд түрээсийн хөрөнгө, түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэх стандартын шаардлагыг тодорхойлоогүй,
- Гүйцэтгэх удирдлагад олгож буй урамшууллын бүртгэл нь НББОУС 19 “Ажилтны тэтгэмж”-т нийцээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль, журам, зааврын өөрчлөлт, өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгаагүй байх, холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн өөрийн байгууллагын онцлогт тохируулан өөрчлөлт оруулах. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС болон СТОУС-ын холбогдох өөрчлөлтүүдийг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны дотор тусгаж, шинэчлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. Ажилтнуудыг холбогдох стандартын шинэчлэлийн талаар сургалтад хамруулна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн программтай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Компани нь “Veritech ERP” санхүү, хүний нөөцийн цогц программыг ашигладаг боловч аудитын явцад уг программ нь дараах сул талуудтай ба алдаа гарах эрсдэл өндөр байна. Үүнд:

- Авлагын насжилтын тайлан гардаггүй,
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангууд алдаатай гардаг,
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд дахин үнэлгээний нэмэгдэл хөрөнгө тус бүрээр харагддаггүй байна.
- Пос машинаар хийгдэж буй ажил гүйлгээг санхүүгийн программтай холбож өгөөгүйгээс нягтлан бодогч нар өөрийн хариуцсан салбарын орлогыг харилцах дансны гүйлгээнээс ялгаж, программд бүртгэхэд ажлын ихэнх цагаа зарцуулдаг.
- Гадаад тооцооны өдөр тутмын гүйлгээг хариуцсан нягтлан бодогч нь excel программаар хөтөлж, улирал бүрийн эцэст бөөн дүнгээр программд бүртгэж байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хангах тухай журмын 1.10 “санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх

үүсвэрийг иж бүрнээр /анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх” гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Хэрэглэгчдийг шаардлагатай санхүүгийн мэдээллээр хангахгүй байх, холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программд холбогдох сайжруулалтыг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор хийх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 СТОУС-ын хэрэгжүүлэлтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Компани нь санхүүгийн тайлангаа Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Маягт, заавар батлах тухай” 361 дүгээр тушаалаар батлагдсан ААН-д мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэдэг боловч СТОУС-ын шаардлага хангасан санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэдэггүй, СТОУС-д нийцсэн аудитын дүгнэлтийг олон нийтэд ил тод болгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, уг стандартыг дагаж мөрдөх үүрэг бүхий байгууллагыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2.1-д “гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлсэн бүх төрлийн хувьцаат компани”, Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-д “Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна” гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, буруу толилуулах, хэрэглэгчдийг шаардлагатай санхүүгийн мэдээллээр хангахгүй байх, холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Стандарт, хууль тогтоомжид нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэж байх;

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5 Компанийн засаглалтай холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодекстэй холбогдуулан дараах зөрчил байна. Үүнд:

- Компани нь нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлогыг баталж мөрдөөгүй,
- Компани нь эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтлөөгүй,
- Компанийн ТУЗ-ийн аудитын хороо нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавьж, дүгнэлт гаргадаггүй байна.

Энэ нь Компанийн засаглалын кодексийн 5.8.1 "Компани нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлоготой байна" , Компанийн тухай хуулийн 91.3. "Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй", Компанийн тухай хуулийн 81.4. "Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна", Компанийн тухай хуулийн 81.4.4 "их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах" гэсэн заалтад тус тус нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Хэрэглэгчдийг шаардлагатай санхүүгийн мэдээллээр хангахгүй байх, холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөн, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлогыг 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор боловсруулах.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

Санхүү эрхэлсэн захирлын ажлын байрны тодорхойлолтын Ажлын байрны үндсэн зорилтын 3-д "Валютын харилцахын 3 данс, зардлын харилцах, хариуцсан салбарын тооцоо бодох" гэсэн зорилтын хүрээнд гүйцэтгэдэг ажлыг шалгах хяналтын тогтолцоо байхгүй, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил гүйлгээг хөтөлсөн байна. Энэ нь санхүү бүртгэлийн үйл явцад өдөр тутмын хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан ажил гүйлгээг бүртгэдэг, түүний бүртгэсэн ажил гүйлгээнд тавих давхар хяналтын тогтолцоогүй байна.

3.6.2. Эрсдэл:

Ажил үүргийн хуваарь тодорхой бус байх, дотоод хяналтын тогтолцоо хангалтгүйгээс санхүүгийн үйл ажиллагаанд алдаа, зөрчил, доголдол үүсэх, ерөнхий нягтлан бодогчийн бүртгэсэн гүйлгээнд хяналтгүй байх.

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Ажил үүргийн хуваарийг өөрчлөн, дотоод хяналт тогтолцоог сайжруулах арга хэмжээ авах.

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.7 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.7.1. Илрүүлэлт:

Эд хөрөнгийн тооллогыг хийхдээ холбогдох дүрэм, журмын хугацааг баримтлаагүй, эд хөрөнгө тоолох журамгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар бүлэг "Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалт, бүртгэл, тооцоо" бүлгийн 70 дугаар зүйл. "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа", 71 дүгээр зүйл. "Эд хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах", 72 дугаар зүйл. "Тооллогын комисс, түүний эрх, үүрэг", 73 дугаар зүйл. "Эд хөрөнгийн тооллого явуулах журам"-д заасан заалтуудад тус тус нийцэхгүй байна.

3.7.2. Эрсдэл:

Дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас хөрөнгө шамшигдах, санхүүгийн үйл ажиллагаанд алдаа доголдол гарах;

3.7.3. Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавих.

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17,267,083,063.60	16,648,915,943.48
1.1.2	Дансны авлага	5,788,142,997.08	4,345,338,954.87
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	11,214,579.94	7,148,982.18
1.1.4	Бусад авлага	368,786,936.46	888,913,568.81
1.1.6	Бараа материал	2,095,115,996.76	2,383,652,392.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	106,902,720.24	189,433,604.75
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	25,637,246,294.08	24,463,403,446.61
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,068,309,950.53	8,725,816,424.32
1.2.2	Биет бус хөрөнгө	304,812,810.22	294,796,411.15
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,373,622,760.75	9,021,112,835.48
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,010,869,054.83	33,484,516,282.08
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
2.1.1.1	Дансны өглөг	10,213,019,917.75	9,560,914,328.30
2.1.1.2	Цалингийн өглөг	0.29	0.29
